



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/314

Хэрлэн сум

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт байрлах Дожир нэртэй MV-016819 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Хан шашир ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг Хан шашир ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүй бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/, Баян-Овоо сумын Засаг дарга /Д.Баянмөнх/ нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах аюулгүйн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

06 Аймгийн Засаг даргын 2019 оны  
дугаар сарын 11 өдрийн 11314  
дугаар захирамжийн хавсралт

Хан шашир ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис,  
тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршил

id	X			Y		
	deg	min	sec	deg	min	sec
1. Тэсрэх бодисын агуулахын хашаа						
1	47	44	22.6	111	47	52.6
2	47	44	25.2	111	47	56.1
3	47	44	23.4	111	48	0.1
4	47	44	20.7	111	47	56.2
2. Тэсрэх бодисын агуулахын байр-1						
1	47	44	22.5	111	47	56.6
2	47	44	22.6	111	47	56.8
3	47	44	22.5	111	47	56.9
4	47	44	22.4	111	47	56.7
3. Тэсрэх бодисын агуулахын байр-2						
1	47	44	22.8	111	47	55.8
2	47	44	23.6	111	47	56.1
3	47	44	22.5	111	47	56.6
4	47	44	22.8	111	47	56.0